



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 79

Мандалговь

“Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв”  
Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн  
газар байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77,4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванзургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөр байгуулсугай.

2. “Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3. “Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулагдсантай холбогдуулан Эрдэнэдалай сумын Засаг даргын тамгын газарт бүртгэлтэй хоёрдугаар хавсралтад дурдсан хөрөнгийг “Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд балансаас балансад шилжүүлсүгэй.

4. Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Энхдэлгэр)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

4.1 Шилжүүлэх хөрөнгийг сум байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хүлээлцэн, холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд бүртгэх,

4.2 Энэ тогтоолын биелэлтийн 2023 оны 12 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

5. “Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгө ашиглалт зарцуулалт, дотоод үйл ажиллагаанд нь хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгч ажиллахыг Эрдэнэдалай сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Н.Чулуун)-д үүрэг болгосугай.

6. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн  
19 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**“Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв”  
Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн  
газрын дүрэм**

**НЭГ. Нийтлэг үндэслэл**

- 1.1. “Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын эрхзүйн байдал, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, удирдлага, хяналт, үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрхийг тодорхойлох, түүнийг өөрчлөн байгуулах, бүртгүүлэх болон холбогдох үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад энэхүү дүрмийн зорилго оршино.
- 1.2. Үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газар байна.
- 1.3. Үйлдвэрийн газар байгуулахаар санаачилсан этгээд нь үйлдвэрийн газрын дүрмээ холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж Орон нутгийн өмчийн газраар хянуулсны үндсэн дээр Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн өргөн барьж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.
- 1.4. Үйлдвэрийн газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын “Үндсэн хууль” Монгол улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хууль, “Төсвийн тухай” хууль, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хууль, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, “Хөдөлмөрийн тухай” хууль, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хууль, Монгол улсын “Хүүхдийн эрхийн тухай”, “Хүүхэд хамгааллын тухай”, “Биеийн тамир, спортын тухай”, “Зөрчлийн тухай”, “Зөрчил шалган шийдвэрлэх тухай” хууль болон Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн холбогдох зүйл заалтууд “Авлигын эсрэг” хууль болон Монгол Улсын бусад хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэр, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, аймаг, сумын Засаг даргын захирамж болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

**Хоёр. Газрын оноосон нэр. Оршин байгаа газар**

- 2.1 Үйлдвэрийн газрын оноосон нэр нь “**Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв**” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /“ Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв” ОНӨААТҮГ/ байна. Түүний хэлбэрийг тодорхойлсон товчлол байж болно.
- 2.2. Үйлдвэрийн газрын байршил нь Дундговь аймгийн Эрдэнэдалай суманд байрлах ба хаягийн өөрчлөлтийг үйлдвэрийн газрын удирдлага тухай бүр харьяа Улсын бүртгэлийн газарт бүртгүүлнэ.

## ГУРАВ. Үйлдвэрийн газрын бэлгэдэл тэмдэг

- 3.1. Эрдэнэдалай сумын “Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь өөрийн бэлгэдэл (эмблем), тэмдэгтэй байхаас гадна хууль тогтоомжид заасны дагуу албан бичгийн хэвлэмэл хуудастай, өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэнэ.
- 3.2 Бэлгэдэл ба тэмдгийн загварыг үйлдвэрийн газраас Улсын бүртгэлийн газарт бүртгүүлсэн байх бөгөөд түүнийг хэрэглэх эрхийг зөвхөн үйлдвэрийн газар эдэлнэ.
- 3.3 Тэмдгээр үйлдвэрийн газрын албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлцлийг баталгаажуулна.
- 3.4 Тэмдгийг үйлдвэрийн газрын дарга, эсхүл даргаас итгэмжлэн хариуцуулсан этгээд түшиж, ашиглалт хамгаалалт хадгалалтыг хариуцна.

## Дөрөв. Үйлдвэрийн газрын төлөөлөн удирдах зөвлөл

- 4.1. Үйлдвэрийн газрын удирдах дээд байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна. /цаашид ТУЗ/ гэж товчлон бичиж болно. Бүрэлдэхүүн менежер, гишүүдийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор томилно.
- 4.2. Үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг менежер удирдана.
- 4.3. Дундговь аймгийн “Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирлыг ТУЗ томилж, чөлөөлнө.
- 4.4. ТУЗ нь дараах эрх хүлээнэ.
  - 4.4.1. Үйлдвэрийн газрын бүтэц, орон тоо цалингийн санг тогтоож батална.
  - 4.4.2. Үйлдвэрийн газрын жилийн орлого, зардлын тооцоог хянаж үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөг хэлэлцэж батлах ба хэрэгжилтэд хяналт тавьж гүйцэтгэлийг хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгнө.
  - 4.4.3. Байгууллагын ажилчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлэх, шагнал урамшуулал олгох санал гаргана.
  - 4.4.4. Өмч хөрөнгө худалдах, шилжүүлэх, актлах, хувьчлах данснаас хасах, 20 сая ба түүнээс дээш үнийн дүнтэй худалдан авалт хийх тохиолдолд менежерийн саналыг хэлэлцэн шийдвэр гаргаж сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжилна.
  - 4.4.5. Мөнгө, үнэт цаас, биет хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж хөндлөнгийн шалгалт, тооллого, аудит хийлгэх зөрчил дутагдалд арга хэмжээ авах эрхтэй.
  - 4.4.6. Менежерийн цалинг тогтоож, нэмэгдэл урамшуулал олгох ба тэтгэвэрт гарах, өөр ажилд шилжих, чөлөөлөгдөх тохиолдолд тухайн байгууллагад ажилласан жил ажлын үр дүнг харгалзан тэтгэмж олгоно.
  - 4.4.7. Шаардлагатай гэж үзвэл өмч хөрөнгө түрээслүүлэх, түр ашиглуулах, үнэ тариф тогтоох, үнэт цаас хэрэглэх журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батална.
  - 4.4.8. Орлого, зарлага төсөв санхүү орон тоо бүтцэд нэмэлт өөрчлөлт оруулна.
  - 4.4.9. Дүрэмд нэмэлт өөрчлөлт хийж болно.
  - 4.4.10. ТУЗ нь эрх хэмжээнийхээ асуудлаар тогтоол, хурлын тэмдэглэл гаргаж, гишүүд гарын үсэг зурснаар тэмдэглэл баталгаажна. Тогтоолд дарга гарын үсэг зурж, үйлдвэрийн газрын тэмдэг дарж баталгаажуулна.

**Тав. Үйлдвэрийн газрын үндсэн зорилго  
үйл ажиллагааны үндсэн чиглэл үүрэг.**



**5.1. Эрхэм зорилго:**

*Орчин үеийн техник технологийн дэвшилтэй уялдуулан сургалтын орчин нөхцөлийг чанартай ханган, үр дүнтэй хэрэгжүүлж, багш эцэг эхийн оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, суралцагчийн хөгжил төлөвшилд ахиц гаргах, хүүхдийн оюун ухаан, хэл, бие бялдрыг өв тэгш хөгжүүлэх орчин үеийн дэвшилтэт техник технологийг эзэмшүүлэх, академик сургалтыг нутагшуулах, ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийг олон улсын нэр хүнд бүхий их дээд сургуулийн элсэлтийн шалгалтад бэлтгэхэд оршино.*

**5.2. Үйлдвэрийн газрын үндсэн чиг үүрэг**

5.2.1 Үйлдвэрийн газар нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг холбогдох эрх бүхий байгууллагын зохих зөвшөөрлөөр эрхэлнэ.

5.2.2. Үйлдвэрийн газар нь гадаад, дотоодын холбогдох байгууллагуудтай зохих журмын дагуу харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллах, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдлэх үүрэг хүлээх, түүнчлэн хуулийн байгууллагад нэхэмжлэгч, хариуцагчаар оролцоно.

5.2.3. Үйлдвэрийн газар нь байгууллагын чадавхыг хөгжүүлэх, материаллаг баазыг бэхжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажиллана.

5.2.4. Үйлчилгээний нэр төрөл, үнэлгээ, нэгж үнэ, тарифыг холбогдох дүрэм, журам, хууль, эрх зүйн баримт бичгийг ТУЗ-ын саналыг үндэслэн Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж мөрдөн ажиллана.

5.2.5. Үйлдвэрийн газар нь өөрийн мэдэлд буй орон нутгийн өмч хөрөнгийг Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн эдэлгээний хугацаа, ашиглалтын горимыг чанд мөрдөж, ариг гамтай эзэмшин ашиглаж, түүний хадгалалт хяналтыг зохион байгуулж, дотоодын тооллогыг "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуульд заасан журмын дагуу хугацаанд нь явуулж, тайлан тэнцэлд тусгана.

5.2.6. Шаардлагатай мэдээ мэдээлэл тооцоог эрх бүхий байгууллагад тухай бүр гаргаж өгч "Татварын тухай" хууль "Нийгмийн даатгалын тухай" хуулийн заалтыг мөрдөж татвар шимтгэлийг хугацаанд нь төлнө.

5.2.7. Үйлдвэрийн газар нь ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, гэрээний заалтуудыг бүрэн биелүүлэх үүрэг хүлээнэ.

5.2.8. Үйлдвэрийн газрын үндсэн ажил үйлчилгээтэй холбоотой хууль, дүрэм заалтын дагуу үйл ажиллагаа явуулж хөдөлмөрийн харилцаанд оролцогч, хэрэглэгчдийн эрх, ашиг сонирхлыг дээдэлнэ.

5.2.9. Үйлдвэрийн газрын үндсэн үйл ажиллагааны чиглэл хөрөнгийн зориулалтыг өөрчлөхгүйгээр үйлчилгээний хүрээг нэмэгдүүлж, хүрсэн түвшнийг бууруулахгүй байх цаашид сайжруулах арга хэмжээг системтэй зохион байгуулна.

5.2.10. Хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйлдвэрийн газрыг хувьчлах, өөрчлөн байгуулах, татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд үйлдвэрийн газар нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

5.2.11. Үйлдвэрийн газар өөрийн үйл ажиллагааны чиглэлд нийцсэн 3 жилийн бизнес төлөвлөгөөтэй байна. Төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллана.

### **Зургаа. Үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх**

6.1. Үйлдвэрийн газар нь өөрийн эзэмшиж байгаа эд хөрөнгийн хэмжээгээр эрх эдэлж, хариуцлага хүлээнэ.

6.2. Үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй байна:

6.2.1. Үйлдвэрийн газар нь үндсэн хөрөнгийг Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн олж авах, акталж данснаас хасах, худалдан борлуулах, устгах, шилжүүлэх

6.2.2. Өөрт олгогдсон үл хөдлөх хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмшиж, ашиглана.

6.2.3. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үр дүнд олсон ашиг нь байгууллагын санхүүжилтийг бүрдүүлэхэд зориулагдана.

### **Долоо. Үйлдвэрийн газрын удирдлага**

7.1. Үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг менежер удирдана.

7.2. Менежер нь шашны байгууллага болон сангийн удирдах ажлыг хавсран гүйцэтгэхийг хориглоно.

7.3. Үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, цалингийн сан, удирдлагын зардал, бизнес төлөвлөгөөг ТУЗ хэлэлцэн баталж хэрэгжилтийг дүгнэнэ.

7.4. Үйлдвэрийн газрын менежер нь тухай жилийн ажлын тайланг Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд дараа оны 1 дүгээр улиралд багтаан тайлагнана.

7.5. Менежер нь ажил олгогч болон Орон нутгийн өмчийн газартай гурван талт гэрээ байгуулж ажиллах бөгөөд гэрээг хагас бүтэн жилд дүгнүүлнэ.

**7.6. Менежер нь дор дурдсан эрх, үүрэгтэй байна.**

7.6.1. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, газрын дүрэм, зорилтын санал, бизнес төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх, үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг шуурхай удирдлагаар хангах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хариуцна.

7.6.2. Орон нутгийн өмчийн газар, харилцагч байгууллага, ажил олгогчтой байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, удирдаж буй газрын хэвийн үйл ажиллагааг хангасны үндсэн дээр санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг бүх талаар дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулна.

7.6.3. Үйлдвэрийн газрын эрх ашгийг дээдэлж, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан ажиллаж аливаа асуудалд ажил хэрэгч идэвх санаачилгатай үнэнч шударгаар хандан байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг биелүүлэх ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлж, ажиллагсдын нийгмийн асуудлыг оновчтой шийдвэрлэж ажиллана.

7.8.4. Ажил үүргээ гүйцэтгэх явцад олж авсан үйл ажиллагааны болон бизнесийн нууцыг чанд хадгалах, хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх.

7.8.5 Менежер нь шаардлагатай материалыг бүрдүүлж асуудлыг шийдвэрлүүлэхээр засаг дарга, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд санал боловсруулж хэлэлцүүлэх,

7.8.6 Менежер нь эдлэх эрх, хүлээх хариуцлага, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин хөлс, урамшуулал, бүтээгдэхүүний тоо зэрэг асуудлыг гэрээнд бүрэн тусгана.

7.8.7. Менежер нь хууль тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрийн дотоод журам боловсруулан баталж мөрдөх ба хувийн эрх ашгийн үүднээс байгууллагын нэрийг ашиглан гэрээ хэлцэл хийхгүй байна.

7.8.8. Үйлдвэрийн газрын менежер нь эрх бүхий байгууллагаас олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, үйлдвэрийн газрыг төлөөлөх зэргээр үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулна.

7.8.9. Тухайн үеийн зах зээлийн бүтээгдэхүүний үнийн өсөлт инфляцын түвшинтэй уялдуулан ажил үйлчилгээний үнэ тариф, ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, өөрчлөх санал, тооцоо гаргаж ТУЗ-д уламжилна.

7.8.10. Ажилчдын нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэж, идэвх санаачилга үр бүтээл, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэн хамт олны хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаарх бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7.8.11. Үйлдвэрийн газрын даргыг нэр дэвшүүлж буй хуулийн этгээд "нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" хуулийн дагуу ХАСУМ, ХАСХОМ-ыг гаргаж АТГ-т хянуулах ба үйл ажиллагааны явцад хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

### **Найм. Газрын санхүү бүртгэл тайлан**

8.1. Үйлдвэрийн газар нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

8.2. Үйлдвэрийн газрын санхүүгийн тайлангийн үнэн зөвийг менежер, нягтлан бодогч нар хариуцна.

8.3. Үйлдвэрийн газрын нягтлан бодогч нь тухайн байгууллагын ажлын байрны тодорхойлолтод нийцсэн хүн байна..

8.4. Үйлдвэрийн Газрын санхүүгийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, мөн оны 12-р сарын 31-ний өдөр дуусгавар болно.

### **Ес. Газрын санхүүжилт, санхүүгийн тайлан**

9.1. Үйлдвэрийн Газрын орлого нь дараах санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ:

9.1.1. Ажил, үйлчилгээнээс олсон бүх орлого;

9.1.2. Төсвийн тухай хууль тогтоомжид заасан санхүүжилт

9.1.3. Байгууллагатай хамтарч ажиллах гэрээний дагуу олсон үйлчилгээний орлого;

9.1.4. Хандивлагчийн тусламж болон буцалтгүй тусламж;

- 9.1.5. Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр;  
9.2. Үйлдвэрийн Газрын санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана:  
9.2.1. Баланс  
9.2.2. Үйл ажиллагааны үр дүнгийн тайлан  
9.2.3. Мөнгөн гүйлгээний тайлан  
9.2.4. Өмчийн өөрчлөлтийн тайлан  
9.2.5. Нэмэлт тайлбар;  
9.2.6. Санхүүгийн тайлангийн тодруулга;  
9.2.7. Бусад;



- 9.3 Менежер нь Орон нутгийн өмчийн газарт тухайн жилийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, зарцуулсан хөрөнгө санхүү, үр дүнгийн талаар тодорхой тусгасан тайлан, илтгэх бичиг, хүргүүлэх бөгөөд тайланд дараах зүйлийг тусгана:  
9.3.1. Тайлангийн хугацаанд үйлдвэрийн газрын эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, түүний өөрчлөлт;  
9.3.2. Тайлангийн хугацаанд удирдах газрын албан тушаалтан, ажиллагсдад олгосон шагнал урамшил, удирдлагын зардлын хэмжээ;  
9.3.3. Шаардлагатай бусад мэдээлэл, тайлбар;

#### **Арав. Үйлдвэрийн газрыг татан буулгах**

10.1. Үйлдвэрийн газар нь цаашид үр өгөөжөө өгөхгүй нь тодорхой болсон тохиолдолд Аймгийн Засаг даргын саналаар Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Монгол улсын "Иргэний тухай" хууль болон бусад хууль тогтоомжид заасан үндэслэл журмын дагуу татан буулгах эсхүл өөрчлөн байгуулна.

#### **Арван нэг. Хариуцлага**

- 11.1. Монгол Улсын хууль тогтоомж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, аймгийн Засаг даргын захирамжийн биелэлтийг хэрэгжүүлэх явцад буруу шийдвэр гаргаж бусдад хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон бол буруутай этгээдэд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.  
11.2. Үйлдвэрийн газрын менежер нь эрх мэдлээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглаж, байгууллагад хохирол учруулсан бол уг хохирлыг өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна.  
11.3. Үйлдвэрийн газрын менежер нь Монгол улсын хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчвөл хариуцлага хүлээлгэнэ.

#### **Арван хоёр. Бусад**

- 12.1. Хуульд нийцүүлэн дүрэмд тусгаснаас бусад асуудлыг хуулиар зохицуулна.  
12.2. Үйлдвэрийн газрын дүрэм нь Монгол улсын Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.  
12.3 Газрын дүрэмд үйл ажиллагааны явцад нэмэлт өөрчлөлт оруулж болно.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн  
19 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗДТГ-ЫН ГАЗРААС "ЭРДЭНЭДАЛАЙ ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ТӨВ"-ИЙН ХӨРӨНГӨД БАЛАНСААС  
БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Данс	Код	Хөрөнгийн нэр	х.нэг ж	Огноо	Ашигла х жил	Нэгж.Үнэ	Эцсийн үлдэгдэл	
							То о	Дүн
Барилга байгууламж	4545	Эрдэнэдалай хүүхэд хөгжлийн төвийн барилга	ш	9/23/2023	40	97278255.86	1	97278255.86
Барилга байгууламж	4545	Байгууллагын Хашаа		6/23/2015	40	48040.02	10	480400.2
Барилга байгууламж		Байгууллагын Хашаа том		6/24/2015	40	95596.86	10	955968.6
Машин тоног төхөөрөмж	343-447	Ухаалаг дэлгэц 86 инч /Ком лаборатори/	ш	2023-11-05	8	17,070,000.02	1	17,070,000.02
Машин тоног төхөөрөмж	344-448	Apple i mac 24 /Ком лаборатори/	ш	2023-11-05	8	7,702,500.00	8	61,620,000.00
Машин тоног төхөөрөмж	348-452	Ухаалаг дэлгэц /Дижитал сургалтын танхим/	ш	2023-11-05	8	17,070,000.00	1	17,070,000.00
Машин тоног төхөөрөмж	349-453	Apple ipad pro 11, pencil, smart key /Дижитал сургалтын танхим/	ш	2023-11-05	8	5,887,000.00	10	58,870,000.00
Машин тоног төхөөрөмж	350-454	Сургалтын камер /mgxhub UCP10/ /Дижитал сургалтын танхим/	ш	2023-11-05	8	3,870,000.00	1	3,870,000.00
Машин тоног төхөөрөмж	351-456	Энгийн микрофон /Дижитал сургалтын танхим/	ш	2023-11-05	8	658,000.00	1	658,000.00



Машин тоног төхөөрөмж	352-457	Документ камер /Дижитал сургалтын танхим/	ш	2023-11-05	8	658,000.00	1	658,000.00
Машин тоног төхөөрөмж	353-458	Charging box /Дижитал сургалтын танхим/	ш	2023-11-05	8	1,835,000.00	1	1,835,000.00
Машин тоног төхөөрөмж	362-468	Хөгжим /Бүжгийн сургалтын өрөө/	ш	2023-11-05	8	5,960,000.00	1	5,960,000.00
Машин тоног төхөөрөмж	363-469	Wireless Router /Дижитал сургалтын танхим/	ш	2023-11-05	8	636,000.00	1	636,000.00
Машин тоног төхөөрөмж	364-477	Jetron Student chair with writing pad /Дижитал сургалтын өрөө/	ш	2023-11-05	8	387,000.00	10	3,870,000.00
Машин тоног төхөөрөмж	371-478	VR motorcycle /Автомат тоглоомын өрөө/	ш	2023-11-05	8	5,800,000.00	2	11,600,000.00
Машин тоног төхөөрөмж	372-479	RM-068 MR Hummer /Автомат тоглоомын өрөө/	ш	2023-11-05	8	5,800,000.00	2	11,600,000.00
Машин тоног төхөөрөмж	373-480	initial D /Автомат тоглоомын өрөө/	ш	2023-11-05	8	9,650,000.00	2	19,300,000.00
Машин тоног төхөөрөмж	374-481	Jurrassic Park, without motion version /Автомат тоглоомын өрөө/	ш	2023-11-05	8	15,450,000.00	1	15,450,000.00
Машин тоног төхөөрөмж	375-482	55 LCD Operation Ghost /Автомат тоглоомын өрөө/	ш	2023-11-05	8	13,500,000.00	2	27,000,000.00
Машин тоног төхөөрөмж	376-483	Air Hockey Table /Автомат тоглоомын өрөө/	ш	2023-11-05	8	8,850,000.00	1	8,850,000.00
Машин тоног төхөөрөмж	377-484	Basketball Street Arcade /Автомат тоглоомын өрөө/	ш	2023-11-05	8	4,095,000.00	2	8,190,000.00
Машин тоног төхөөрөмж	378-495	Soft toy Claw Machine /Автомат тоглоомын өрөө/	ш	2023-11-05	8	4,700,000.00	2	9,400,000.00
Машин тоног төхөөрөмж	379-486	2015 Pump it up dance Prime game machine /Автомат тоглоомын өрөө/	ш	2023-11-05	8	14,350,000.00	1	14,350,000.00

Машин тоног төхөөрөмж	380- 487	Karaoke booth /Автомат тоглоомын өрөө/	ш	2023-11-05	8	11,600,000.0 0	1	11,600,000.00
Машин тоног төхөөрөмж	381- 488	Mars boxing game /Автомат тоглоомын өрөө/	ш	2023-11-05	8	14,350,000.0 0	1	14,350,000.00
Машин тоног төхөөрөмж	382- 489	Owatch VR Egg Chair 9D /Автомат тоглоомын өрөө/	ш	2023-11-05	8	18,750,000.0 0	1	18,750,000.00
Машин тоног төхөөрөмж	383- 490	Transformers /Автомат тоглоомын өрөө/	ш	2023-11-05	8	2,885,000.00	2	5,770,000.00
Машин тоног төхөөрөмж	384- 491	Olympic Shooting /Автомат тоглоомын өрөө/	ш	2023-11-05	8	14,350,000.0 0	1	14,350,000.00
Машин тоног төхөөрөмж	385- 492	Photo booth /Автомат тоглоомын өрөө/	ш	2023-11-05	8	14,350,000.0 0	1	14,350,000.00
Машин тоног төхөөрөмж	386- 493	Зөөлөн тоглоомын байгууламж	ш	2023-11-05	5	24,050,000.0 0	1	24,050,000.00
Машин тоног төхөөрөмж	387- 494	Камер CCTV 1080P /Автомат тоглоомын өрөө/	ш	2023-11-05	8	393,000.00	25	9,825,000.00
Тавилга, аж ахуйн эд хогшил	345- 449	Сандал /Ком лаборатори/	ш	2023-11-05	5	298,818.18	11	3,286,999.98
Тавилга, аж ахуйн эд хогшил	346- 450	Ширээ /Ком Лаборатори/	ш	2023-11-05	5	680,000.00	1	680,000.00
Тавилга, аж ахуйн эд хогшил	347- 451	Багшийн ширээ /Ком лаборатори/	ш	2023-11-05	5	1,065,000.00	1	1,065,000.00
Тавилга, аж ахуйн эд хогшил	354- 459	Дэвжээний матрасс иж бүрдэл /Бөх/	ш	2023-11-05	5	8,270,000.00	1	8,270,000.00
Тавилга, аж ахуйн эд хогшил	355- 460	Шүүгээ /Бөх/	ш	2023-11-05	5	615,000.00	2	1,230,000.00
Тавилга, аж ахуйн эд хогшил	356- 461	Сандал /Бөх/	ш	2023-11-05	5	390,000.00	4	1,560,000.00
Тавилга, аж ахуйн эд хогшил	357- 462	Бэлтгэлийн хиймэл хүүхэлдэй /Бөх/	ш	2023-11-05	5	515,000.00	1	515,000.00

Тавилга, аж ахуйн эд хогшил	360-466	Сандал /Бүжгийн сургалтын өрөө/	ш	2023-11-05	5	395,000.00	2	790,000.00
Тавилга, аж ахуйн эд хогшил	361-467	Шүүгээ /Бүжгийн сургалтын өрөө/	ш	2023-11-05	5	625,000.00	4	625,000.00
Тавилга, аж ахуйн эд хогшил	366-472	Сурагчийн ширээ /IQ/	ш	2023-11-05	5	316,000.00	8	2,528,000.00
Тавилга, аж ахуйн эд хогшил	367-473	Сандал сурагч/IQ/	ш	2023-11-05	5	94,750.00	16	1,516,000.00
Тавилга, аж ахуйн эд хогшил	368-474	Багшийн ширээ /IQ/	ш	2023-11-05	5	1,065,000.00	1	1,065,000.00
Тавилга, аж ахуйн эд хогшил	369-475	2 талдаа хөлтэй самбар /IQ/	ш	2023-11-05	5	438,000.00	1	438,000.00
Тавилга, аж ахуйн эд хогшил	370-476	Багшийн ширээ /Дижитал сургалтын өрөө/	ш	2023-11-05	5	1,065,000.00	1	1,065,000.00
Тусгай зориулалттай материал	276	Бариул /Бүжгийн сургалтын өрөө/	ш	2023-11-05		295,000.02	1	295,000.02
Тусгай зориулалттай материал	277	Гэрэл /Бүжгийн сургалтын өрөө/	ш	2023-11-05		95,500.00	10	955,000.00
Тусгай зориулалттай материал	272	Сарабон санпин/iQ/	ш	2023-11-05		50,750.00	16	812,000.00
Тусгай зориулалттай материал	275	Толь /Бүжгийн сургалтын өрөө/	ш	2023-11-05		280,000.00	4	1,120,000.00
Тусгай зориулалттай материал	274	төрөл бүрийн оньсон тоглоом/iQ/	ш	2023-11-05		30,950.00	16	495,200.00
Тусгай зориулалттай материал	265	хөлөгт тоглоом шатар/iQ/	ш	2023-11-05		41,000.00	8	328,000.00
Тусгай зориулалттай материал	264	хөлөгт тоглоом даам/iQ/	ш	2023-11-05		41,000.00	8	328,000.00
Тусгай зориулалттай материал	267	Хурдны аяга/IQ/	ш	2023-11-05		28,750.00	16	460,000.00

Тусгай зориулалттай материал	270	хурдны цаг/IQ/	ш	2023-11-05	103,466.66	3	310,399.98
Тусгай зориулалттай материал	273	Шатрын цаг/iQ/	ш	2023-11-05	96,000.00	8	768,000.00
Тусгай зориулалттай материал	266	Шоо/ IQ/	ш	2023-11-05	28,125.00	32	900,000.00
<b>Дүн</b>						<b>257</b>	<b>442,307,600.00</b>

407000000  
 407000000  
 407000000  
 407000000